

JENESYS 2.0 Хөтөлбөрт оролцох орон нутгийн ахлах сургуулийн сурагчдын хөтөлбөр

6 дугаар сарын 30 (Даваа)

Япон улс руу явахын өмнөх танилцуулга хийв.

(Кемпински Хаан Палас Зочид Буудал, 2-р давхрын Алтай Танхим)

7 дугаар сарын 1 (Мягмар)

Япон улсын нийслэл Токио хотод очсоны дараа нэгдсэн танилцуулга уулзалт хийв.

7 дугаар сарын 2 (Лхагва)

Токио хот болон дэвшилтэт технологитой танилцав

7 дугаар сарын 3 (Пүрэв) – 6 (Ням)

2 группэд хуваагдан Тохокү групп нь Иватэ мужийн Күжи хот руу,

Кюүшү групп нь Миязаки мужийн Мияконожёо хот руу явав.

Тохокү групп

Орон нутгийн захиргааны байгууллагаар зочлож, жижиг оврын загас агнуурын онгоцонд сууж далайгаар аялан, Иватэ мужийн Күжихигаши ахлах сургуулиар орж, япон айлд байрлан, хөтөлбөрийн төгсгөлд санал солилцох уулзалт хийснээр өндөрлөв.

Кюүшү групп

Орон нутгийн захиргааны байгууллагад зочлож Мияконожёо олон улсын харилцааны нийгэмлэгийн үйл ажиллагаатай танилцан, Кимоно болон Юката (зуны нимгэн кимоно) өмсөж уламжлалт бүжиг соёлтой танилцан, Мияконожёо техникийн ахлах сургуульд зочлон, япон айлд байрлаж, нутаг буцахын өмнө санал солилцох уулзалт хийснээр уг хөтөлбөр өндөрлөсөн юм.

7 дугаар сарын 7 (Даваа)

Орон нутгаас Токио хотод буцаж ирээд тайлан уулзалт хийв. (Хөтөлбөрт оролцсоны дараах сэтгэгдэл болон үр дүнг дүгнэх тайлан уулзалт хийж эх орондоо очсоны дараах төлөвлөгөө зэргийг танилцууллаа)

7 дугаар сарын 8 (Мягмар)

Нарита Олон улсын онгоцны буудлаас нутгийн зүг жолоо залж 23:40д Улаанбаатарт бууна.